

«МАОИЗМ БА ҮНДЭСТНИЙ АСУУДАЛ»**(Улаанбаатарт болсон олон улсын эрдэм шинжилгээний симпозиум)**

БНМАУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгээс 1979 оны 5-р сарын 30-наас 6-р сарын 2-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо хуралдуулсан «Маоизм ба үндэстний асуудал» сэдэвт олон улсын хятад судлалын эрдэм шинжилгээний ээлжит симпозиумд БНБАУ, БНУАУ, БНСВУ, БНАГУ. Куба, БНМАУ, БНПАУ, ЗСБНХУ, БНСЧСУ-ын хятад судлаач нэрт эрдэмтдээс гадна эдгээр ах дүү социалист орнуудын коммунист, ажилчны намын төв хороодын хариуцлагатай ажилтнууд оролцов. БНМАУ-ын ШУА-ийн ерөнхийлөгч, академич Б. Ширэндэв симпозиумыг нээж хэлсэн үгэндээ, ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн орнуудын оруулсан одоо ч оруулж байгаа хүчин чармайлтаар үүсэн бий болсон намжмал байдал бол орчин үеийн олон улсын уур амьсгалыг зөөлрүүлэх дорвитой хүчин зүйл гарцаагүй мөн гэдгийг манай өдөр дутмын амьдрал батлан харуулж байна гэж онцлон тэмдэглээд, БНХАУ-д ноёрхож байгаа маоизмын харгис мөн чанар нь бүх талаараа тод илчлэгдэж байгааг БНХАУ-ын үндэстний цөөнхүүдийн хяхан хавчигдсан байдлаас ч харж болно гэж дүгнэлээ.

Симпозиумд БНМАУ-ын ШУА-ийн дэд ерөнхийлөгч, Дорно дахины судлалын хүрээлэнгийн захирал, академич Ш. Бира «Маоизм, хятад дахь үндэстний асуудал», «ЗСБНХУ-ьга ШУА-ийн сурвалжлагч гишүүн М. И. Сладковский «Нэгдмэл нэг хятад үндэстний тухай их хан үндэстний номнол», Чехословакийн Коммунист Намын Төв Хорооны Марксизм-ленинизмийн институтын орлогч захирал, доктор М Матоуш «Их гүрний дээрэнгүй үзэл-дэлхий дахины хөгжил дэвшлийн дайсан мөн» Вьетнамын Коммунист Намын Төв Хорооны дэргэдэх Намын дээд сургуулийн философийн тэнхимийн эрхлэгч Нго Тхань Зыонг «Бээжингийн харгис бүлгийнхнээс Вьетнамын эсрэг явуулж байгаа их гүрний булаан эзлэх, жанжлах, үндсэрхэг үзэл» гэсэн сэдвүүдээр илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Эдгээр илтгэлүүд хятадын эрх баригчид БНХАУ дахь хятад биш ард түмний талаар жижиг үндэстнүүдийг хүчээр уусган хятадчилах их хан үндэстний үндсэрхэг дээрэнгүй бодлогоо хэвээр үргэлжлүүлж байгааг нотлон харуулаад, Бээжингийн удирдагчид энэ харгис бодлогоо элдвээр цагаатгахыг эрмэлзэн БНХАУ-д зөвхөн нэгдмэл нэг хятад үндэстэн оршиж байгаа мэтээр сурталддагийг илчлэн няцаалт өглөө. Мөн илтгэлүүдэд Бээжингийн удирдагчдын их хан үндэстний дээрэнгүй бодлого хичнээн аюултай нь Социалист Вьетнам улсын эсрэг үйлдсэн хятадын түрэмгийлэл, Кампучийн ард түмнийг хүйс тэмтрэх, Лаосыг бусниулах гэсэн балмад өдөөн хатгалгаар илэрч байгааг баримтаар харуулав. Тийм өдөөн хатгалга нь хятадын эрх баригчид пролетарийн интернационализмын зарчмыг хөсөрдүүлээд зогсоогүй, социалист хамтын нөхөрлөлийн орнуудыг илт дайсагнагч замд шилжин орж тэрхүү дайсагнагч чиг шугам нь маоистуудын гадаад бодлогын зонхилох нэг гол шинж болж байгааг илтгэлүүдэд тэмдэглэлээ.

Симпозиум дээр монголын болон ах дүү социалист орнуудын хятадыг судлагч эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтан 20 гаруй хүн илтгэл тавьж, үг хэллээ. Эдгээр илтгэлүүд, хэлсэн үгэнд хятадын эрх баригчдын хэлбэр төдий тунхагласан үндэстний районы автономит систем нь БНХАУ дахь хятад биш ард түмэн өөртөө засан тогтнох эрхээ эдэлж чадаагүйгээр барахгүй, үй олон сая хятад биш ард түмэн оршин суудаг үндэстний районууд, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарилалтаар зэргэлдээх олон хүн амтай хятад мужуудад тасчигдан захирагдаад үнэн хэрэг дээрээ хятад мужуудыг түүхий эдээр хангагч хавсарга болсныг бодит баримтаар нотлон харууллаа. Иймээс хятадын үндэстний районууд дахь одоогийн системийн нийгэм эдийн засгийн бодлогын мөн чанар нь тэдгээр үндэстний районуудын аж ахуй, соёлын хоцрогдлыг улам даамжруулж үндэстнүүдийн урагшлан хөгжихөд саад тотгор болж байгаа бөгөөд Бээжингийн удирдагчдын одоогийн явуулж байгаа «дөрвөн шинэчлэлт» гэгч улс-нийгмийн амьдралыг цэрэгжүүлэх зорилгод захирагдаж байгааг илтгэгчид, уг хэлэгсэд илчлэв.

БНХАУ дахь хятад биш ард түмнүүдийн талаар Бээжингийн эрх баригчид их хан үндэстний дээрэнгүй бодлогоо үргэлжлүүлэн, тэдгээр үндэстэн ястнуудыг хүчээр уусган хятадчилж байгаагийн зэрэгцээгээр Синьцзян, Өвөр Монгол, Төвд зэрэг хил хязгаарын үндэстний районуудыг ЗСБНХУ, БНМАУ, БНСВУ зэрэг хөрш зэргэлдээ бусад улс орнуудад өдөөн хатгалга хийх, хурцадмал байдал бий болгох цэрэг-дайны түшиц газар болгож байгааг симпозиумд оролцогсод цохон тэмдэглэв.

Олон улсын эрдэм шинжилгээний симпозиумд оролцсон монголын болон ах дүү социалист орнуудын эрдэмтэд БНХАУ дахь хятад биш үндэстэн ястны түүх, эдийн засаг, соёлыг цаашид марксист-ленинист онолын үндсэн дээр үргэлжлэн судалж, бээжингийн маоист эрх баригчдаас үндэстний районуудад явуулж байгаа их хан үндэстний үндсэрхэг дээрэнгүй бодлогыг илчлээд цаашид маогийнхны хөрш зэргэлдээ орнуудынхаа нутаг дэвсгэрт өнгөлзөх, түрэмгийлэн эзлэх, жанжлах зорилгодоо хүрэхийн тулд орчин үеийн зүсэн бүрийн харгис хүчин арьсны үзэлтэн, милитарист, хонзогногчид, неофашистууд зэрэгтэй эвсэн нийлж, дэлхий дахины энх тайван, бодит социализмыг эсэргүүцсэн аюул занал учруулж байгааг шүүмжилж, няцаалт өгч байх нь чухал гэж үзэв.

Ч. Бямба